

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гүний Ус ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2023/13-НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: www.audit.mn Өмнөговь аймаг 2023 он</p>	<p>Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас:99014247 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Болормаа Утас:80077408 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Азуре хүлүг аудит ХХК Утас:70110090 Цахим хаяг: audit@azure.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.02.15 № 213

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Гүний ус ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Гүний ус ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр “Даланзадгад сумын төвийн гэр хороололд цэвэр, бохир усны шугам сүлжээг өргөтгөж, ус түгээх байр шинээр барих” ажилд 1,883.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд 2,422.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,358.6 сая төгрөг зарцуулж, 89.8 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй бусад асуудал байхгүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

016020281

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
2	Эргэлтийн хөрөнгө		
3	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	108,669,950.52	77,569,634.97
2	Дансны авлага	354,572,520.57	81,934,273.00
4	Татвар, НДШ - ийн авлага	17,794,911.72	-
5	Бусад авлага	4,888,383.83	5,286,579.38
3	Бусад санхүүгийн хөрөнгө	22,115,533.88	37,708,210.95
6	Бараа материал	194,453,244.32	340,308,936.30
7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	14,299,420.00
5	Эргэлтийн хөрөнгийн дүн	702,494,544.84	557,107,054.60
10	Эргэлтийн бус хөрөнгө		
11	Үндсэн хөрөнгө	22,352,651,255.14	24,000,304,357.12
6	Биет бус хөрөнгө	57,952,027.15	57,578,849.42
12	Биологийн хөрөнгө	-	-
13	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
7	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
14	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	40,194,488.00
17	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	22,410,603,282.29	24,098,077,694.54
9	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	23,113,097,827.13	24,655,184,749.14
18	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
19	Өр төлбөр		
10	Богино хугацаат өр төлбөр		
20	Дансны өглөг	128,523,192.90	-
21	Цалингийн өглөг	-	-
11	Татварын өр	83,130,290.83	56,275,677.62
22	НДШ - ийн өглөг	-	-
23	Богино хугацаат зээл	-	-
12	Хүүгийн өглөг	769,117,726.11	749,656,001.48
25	Урьдчилж орсон орлого	221,711,815.00	17,012,455.00
26	Бусад богино хугацаат өр төлбөр	822,145,812.39	888,901,492.39
28	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,024,628,837.23	1,711,845,626.49
29	Урт хугацаат өр төлбөр		
15	Урт хугацаат зээл	558,743,659.22	381,653,103.04
31	Хойшлогдсон татварын өр	-	-
16	Бусад урт хугацаат өр төлбөр	19,049,935,859.49	20,993,939,098.75
33	Урт хугацаат өр төлбөрийн дүн	19,608,679,518.71	21,375,592,201.79
17	Өр төлбөрийн нийт дүн	21,633,308,355.94	23,087,437,828.28
34	Эздийн өмч		
35	Өмч: - төрийн	306,281,928.00	306,281,928.00
18	-хувийн	294,270,872.00	294,270,872.00
36	-хувьцаат	-	-
38	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	146,163,404.76	146,163,404.76
20	Эздийн өмчийн бусад хэсэг	299,802,302.33	299,802,302.33
40	Хуримтлагдсан ашиг	433,270,964.10	521,228,413.77
21	Эздийн өмчийн дүн	1,479,789,471.19	1,567,746,920.86
42	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	23,113,097,827.13	24,655,184,749.14

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,768,520,779.22	2,009,839,216.37
2	Борлуулалтын өртөг	1,853,655,188.51	2,900,389,663.57
3	Нийт ашиг (алдагдал)	(85,134,409.29)	(890,550,447.20)
4	Түрээсийн орлого	1,909,090.89	3,090,909.06
5	Хүүгийн орлого	235,738.24	2,016,273.41
6	Ногдол ашгийн орлого	-	-

7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	490,114,301.72	1,387,160,055.21
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	281,843,725.73	353,343,800.54
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	42,773,278.54	21,153,714.52
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(177,259.32)	(29,981,462.57)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	82,330,457.97	97,237,812.85
19	Орлогын татварын зардал	6,264,049.79	7,418,649.50
20	Татварын дараах ашиг (алдагдал)	76,066,408.18	89,819,163.35
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
24	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
25	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
26	Бусад олз (гарз)	-	-
27	Орлогын нийт дүн	-	-
28	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	600,552,800.00	146,163,404.76	9,624,145,607.23	358,946,159.04
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	(9,379,153,604.90)	-	(9,379,153,604.90)
Залруулсан үлдэгдэл	600,552,800.00	146,163,404.76	244,992,002.33	358,946,159.04
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	76,066,408.18	76,066,408.18
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	54,810,300.00	-	54,810,300.00
Зарласан ногдол ашиг	-	-	(1,741,603.12)	(1,741,603.12)
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	600,552,800.00	146,163,404.76	299,802,302.33	433,270,964.10
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	600,552,800.00	146,163,404.76	299,802,302.33	433,270,964.10
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	89,819,163.35	89,819,163.35
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	(1,861,713.68)	(1,861,713.68)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	591,173,073.75	45,899,961.06	(93,583,663.22)	543,489,371.59

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		

2	Мөнгөн орлогын дүн (+)	2,268,047,274.25	3,233,887,618.50
3	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,673,057,837.75	2,462,910,673.97
4	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
5	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	11,790,532.00	-
6	Буцаан авсан албан татвар	-	-
7	Татаас, санхүүжилтийн орлого	200,036,207.00	245,144,549.00
8	Бусад мөнгөн орлого	383,162,697.50	525,832,395.53
9	Мөнгөн зарлагын дүн (-)	2,000,648,627.08	3,152,945,392.42
10	Ажиллагчдад төлсөн	625,960,217.00	741,894,495.61
11	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	184,303,331.23	212,943,529.29
12	Бараа материал худалдан авахад төлсөн	605,829,169.70	1,134,713,759.86
13	Ашиглалтын зардалд төлсөн	142,713,426.11	393,800,287.82
14	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	110,544,723.00	209,325,538.80
15	Хүүгийн төлбөрт төлсөн	-	19,867,350.97
16	Татварын байгууллагад төлсөн	165,459,640.62	318,745,064.31
17	Даатгалын төлбөрт төлсөн	7,214,362.00	8,654,738.00
18	Бусад мөнгөн зарлага	158,623,757.42	113,000,627.76
19	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	267,398,647.17	80,942,226.08
20	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
21	Мөнгөн орлогын дүн (+)	235,738.24	2,016,273.41
22	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
23	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
24	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
25	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
27	Хүлээн авсан хүүгийн орлого	235,738.24	2,016,273.41
30	Мөнгөн зарлагын дүн (-)	168,180,100.00	112,383,272.73
31	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	168,180,100.00	112,383,272.73
32	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
33	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
37	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(167,944,361.76)	(110,366,999.32)
38	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
39	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
40	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
41	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
42	Төрөл бүрийн хандив	-	-
44	Мөнгөн зарлагын дүн (-)	46,216,403.12	1,675,542.31
45	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
46	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	44,474,800.00	-
47	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
48	Төлсөн ногдол ашиг	1,741,603.12	1,675,542.31
50	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(46,216,403.12)	(1,675,542.31)
51	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	53,237,882.29	(31,100,315.55)
52	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	55,432,068.23	108,669,950.52
53	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	108,669,950.52	77,569,634.97

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Тайлант оны (2022)			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,085,925,650.00	2,009,839,216.37	(76,086,433.63)	96.35
2	Борлуулалтын өртөг	2,056,474,680.00	2,900,389,663.57	843,914,983.57	141.04
3	Нийт ашиг (алдагдал)	29,450,970.00	(890,550,447.20)	(920,001,417.20)	3,023.84

4	Үйл ажиллагааны зардал	302,143,900.00	353,343,800.54	51,199,900.54	116.95
5	Үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/	(302,143,900.00)	(353,343,800.54)	(51,199,900.54)	116.95
6	Туслах үйл ажиллагааны орлого	336,203,770.00	1,392,267,237.68	1,056,063,467.68	414.11
7	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	35,381,400.00	51,135,177.09	15,753,777.09	144.53
8	Үндсэн бус үйл ажиллагааны ашиг /алдагдал/	300,822,370.00	1,341,132,060.59	1,040,309,690.59	445.82
9	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	28,129,440.00	97,237,812.85	69,108,372.85	345.68
10	Орлогын татварын зардал	7,812,500.00	7,418,649.50	(393,850.50)	94.96
11	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	20,316,940.00	89,819,163.35	69,502,223.35	442.09

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 50.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 50.5 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/					
								Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Бараа материалын зарлагын ажил гүйлгээ нь баримтын иж бүрдэл хангаагүй байна.	1	-							1	-	1	-
2	Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 1,789 үндсэн хөрөнгө байна.	1	-							1	-	1	-
	Дүн	2	-							1	-	1	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Ажилчдад 24,060.2 сая төгрөгийн урамшуулал, мөнгөн шагнал олгосон байна.	1	24,060.2			1	24,060.2						
2	Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан үнэлгээний хорооны гишүүдийн АЗ сертификатын хугацаа дууссан, тендерт шалгарсан гүйцэтгэгчтэй гүйцэтгэх захирал гэрээ байгуулаагүй мөн нэмэгдсэн өртгийн албан татварыг тооцоолон төлөвлөгөөнд тусгаагүй байна.	1	-			1	-						
	Дүн	2	24,060.2			2	24,060.2						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 4 зөрчил¹ илэрснээс нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй тул 1 зөвлөмж, төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй тул 2 төлбөрийн акт тогтоож, шилэн дансны цахим сайтад байршуулах мэдээллийг хуульд заасан хугацаанд байршуулж ажиллах талаар 1 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Анхан шатны баримтын иж бүрдэл хангаагүй 25,945.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байна.	1	-					1	-
	Дүн	1	-					1	-
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Байгууллагын хөрөнгөөр 1,604.4 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна.	1	1,604.4	1	1,604.4	-	-	-	-
2	Байгууллагын хөрөнгөөр 3,187.2 мянган төгрөгийн ажилчдын гар утасны төлбөр төлсөн байна.	1	3,187.2	1	3,187.2	-	-	-	-
	Дүн	2	4,791.6	2	4,791.6	-	-	-	-
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	1	-	-	-	-	-	1	-
	Дүн	1	-	-	-	-	-	1	-
	Нийт дүн	4	4,791.6	2	4,791.6			2	-

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

